

3. ЗӨГИЙН БҮЛД ҮЗЛЭГ ХИЙХ ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИ



ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

3-1. Утуур ашиглах	69
3-2. Зөгийн бүлд үзлэг хийх ерөнхий арга, дараалал	69
3-3. Зөгийн эрүүл мэнд, эрүүл ахуй, зөгийн балны гарал үүслийн бүртгэл хөглөх	70

3-1. Утуур ашиглах

Утаа мэдэрсэн зөгий нь түймэр гарлаа гэж ойлгон тэжээлээ биедээ нөөцөлж эхлэх ба хоол тэжээл идсэнээр тайван дөлгөөн болдог. Энэ араншинг нь ашиглан зөгийн бүлд үзлэг хийх үедээ утаж байх нь зөгийг номхон дөлгөөн байлгаж эрсдэлд оруулахгүй, мөн зөгийчин ажил хийхэд хялбар болдог. Утуур хэрэглэхгүйгээр зөгийд үзлэг хийж хэрхэвч БОЛОХГҮЙ.

- Утууранд байгалийн гаралтай зүйлийг шатааж хэрэглэх шаардлагатай. Монгол орны нөхцөлд аргал, хомоол хамгийн тохиромжтой юм.
- Утуураа асаасны дараа утааг зөгийчин гар руугаа үлээлгэж хэт халуун агаар, цог гарч буй эсэхийг шалгаж зөгийн бие, далавч шатахаас сэргийлээрэй.
- Утуурыг хэсэг хугацаанд ашиглахгүй болох үедээ хошууг нь бөглөж тавих нь түлшийг хэмнэх, хажуу талаараа унаж орчиндоо галын аюул үүсгэхээс сэргийлэх сайн талтай.
- Утуурын хошууны дотор талыг ойрхон цэвэрлэж байвал утаа сайн гарч, доторх түлш унтрахгүй удаан шатдаг.



3-2. Зөгийн бүлд үзлэг хийх ерөнхий арга, дараалал

1. Үзлэг хийх гэж буй хүн торон малгай, цамц, өмд, бээлий, түрийтэй гутал зэрэг зөгийчний хувцас өмссөн байна. Зөгий хар бараан өнгөнд дургүйцэж дайрах хандлагатай байдаг тул зөгийн суурьт ажиллах үедээ үсээ бүрэн далдалж цайвар өнгийн хувцас өмсөнө. Үнэртэй ус, спиртлэг зүйл хэрэглэсэн үедээ зөгийн бүлд ойртвол зөгий дайрдаг тул болгоомжлох хэрэгтэй.
2. Зөгийн үүр хайцагны тагийг нээхийн өмнө үүрний эргэн тойрон, нисгэвч хэсгийг хөнгөн утна.
3. Зөгийн нислэгт саад болохгүйгээр хайрцагны хажуу талд гарч тагийг нээж дэр, цаваг даавууг утангаа аажуухан авах шаардлагатай.
4. Үзлэг хийж байхдаа огцом ширүүн хөдөлгөөн хийхгүй ба зөгий бужигнах маягтай бол зөөлнөөр утна.
5. Захын жаазыг авч үзсэний дараа зөөврийн хайрцагт хийж дараагийн жаазыг хайрцагны хана руу шахаж тавина. Жаазыг өргөж авах буцааж, хийхдээ зөгий бяцрахаас болгоомжлох хэрэгтэй. Зөгий дарагдаж бяцрахад түгшүүрийн феромон (alarm pheromone) ялгарснаас бусад зөгий үймэлдэж эхэлдэг.
6. Нялх өндөгтэй жаазыг голд нь, түүний гадна талд хаалтгүй үрвэлдэйтэй жааз, тэгээд хаалттай үрвэлдэйтэй жааз, цэцгийн тоосормогтой жааз, балтай жааз гэсэн дарааллаар байрлуулна.
7. Жаазыг шууд газар тавилгүйгээр тохуур болон зөөврийн хайрцагт хийж байх.
8. Үзлэгээр дараах зүйлүүдийг ажиглаж арга хэмжээ авах шаардлагатай:

- Тэжээлийн хүрэлцээ (бал, тоостой жааз хангалттай байгаа эсэх)
 - Эх зөгийг ажиглах (байгаа эсэх, хөдөлгөөн, будагны өнгө г.м.)
 - Өндөг, үрвэлдэй хангалттай байгаа эсэх
 - Өндөглүүлэх ташаалавч нэмэх зорилгоор балтай ташаалавч эвдэх эсэх
 - Шинээр өндөглүүлэх, бал хураалгах жааз нэмэх, эсвэл хасах эсэх
 - Өлгийвч барьсан эсэх
 - Зөгийн үүр хайрцганд цэвэрлэгээ хийх, солих шаардлагатай эсэх
 - Хачиг болон бусад өвчний шинж тэмдэг байгаа эсэх
 - Эцэст нь жаазнуудын байрлал, хоорондын зайг тохируулж тавина.
9. Зөгийн бүлийн үзлэгийг дуусгаад дээрх мэдээлэл, авсан арга хэмжээ, мөн дараагийн үзлэгээр анхаарах шаардлагатай зүйлсийг бүртгэлийн дэвтэрт бүртгэж байна.

3-3. Зөгийн эрүүл мэнд, эрүүл ахуй, зөгийн балны гарал үүслийн бүртгэл хөтлөх

А. Зөгийн аж ахуй эрлэгч

Зөгийн бал үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр хэрэглэгч буюу үйлчлүүлэгчийн зүгээс гарал үүсэл нь тодорхой, эрүүл аюулгүй бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэх, мөн нөгөө талаас зөгийн аж ахуй эрхлэгч нь өрсөлдөөнтэй зах зээлд амжилттай оршин тогтнохын тулд хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц чанартай (стандартад нийцсэн) бүтээгдэхүүнийг зах зээл (дотоод, гадаад)-д нийлүүлж байгаа эсэхээ баталгаажуулах шаардлага улам бүр өссөөр байна. Энэхүү баталгаажуулалтыг зөгийн балны мөшгих систем бий болгодог. Зөгийн аж ахуй эрхлэгч нь “ЗӨГИЙН ЭРҮҮЛ МЭНД, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН БҮРТГЭЛ”-ийг үнэн зөв, тогтмол хөтөлж гэрээт малын эмчид хянуулснаар системийг мэдээллээр хангах буюу системийн оролцогч тал болно.



Бүртгэлийн ерөнхий агуулга:

1. Зөгийн суурийн хяналт – Бал хураалтын хяналт
2. Зөгийн бүлийн хяналт
3. Бүтээгдэхүүний хяналт
4. Багаж хэрэгслийн эрүүл ахуйн хяналт

Бүртгэлийг тогтмол, чанартай хөтлөх нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Бүтээгдэхүүнийхээ эрүүл, аюулгүй байдлыг илтгэх суурь материал бий болно.
- Бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн цаашдын үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөх нөхцөл бүрдэнэ.
- Өмнө гаргасан алдааг давтахгүй байх боломж бүрдэнэ.

- Эрсдэл үүссэн үед учир шалтгааныг зөв тодорхойлох боломж нэмэгдэнэ.
- Төрийн болон хамтрагч талуудын дэмжлэгийг авахад сайн нөлөө үзүүлнэ.

“Зөгийн эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуйн бүртгэлийн дэвтэр”-ийн загварыг Хавсралт 1-ээс харна уу.

Б. Малын эмч (Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж)

Малын эмч нь Зөгийн аж ахуйд Мал эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөх нийтлэг зааварт заасны дагуу зөгийн аж ахуй эрхлэгчийн хөтөлж буй “Зөгийн эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуйн бүртгэл”-ийн мэдээллийг хянаж, баталгаажуулах (бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурах) үүрэг хүлээдэг. Тус бүртгэл дэх мэдээллүүдийн үр дүнг “ЗӨГИЙН ЭРҮҮЛ МЭНД, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ДЭВТЭР”-т зөгийн аж ахуй тус бүрээр бүртгэх ба үүнийг Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч хянаж баталгаажуулдаг. Ийнхүү тухайн зөгийн аж ахуйн мэдээллийн дүн, эрүүл мэндийн тандах үзлэгийн дүнд үндэслэн зөгийн бүл болон зөгийн баланд Мал эмнэлгийн гэрчилгээ (гарал үүслийн гэрчилгээ) олгоно. Эцэст нь Мал эмнэлгийн гэрчилгээ тус бүрийн мэдээллийг Мал эмнэлгийн нэгдсэн мэдээллийн санд илгээнэ. Энд бүртгэгдсэн мэдээлэл ЗБМС-д ашиглагдах болно.

“Зөгийн эрүүл мэнд, ариун цэвэр, эрүүл ахуйн бүртгэлийн хяналтын дэвтэр”-ийн загварыг Хавсралт 2-оос харна уу.



